



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/036НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Дорнод аймаг</p> <p>2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

ДОАБ. 01-23 № 180
танай ДОАБ. 01-23-ны № 25 -Т

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА
Б.АЛТАНСҮХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 551.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд бүртгэлтэй 547.1 сая төгрөгийн үнэтэй Хэрлэн сумын 2 багт байрлалтай спорт заалны зориулалттай барилгыг иргэн С.Өнөрхүүтэй орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтын гэрээгээр ашиглуулахаар байгуулсан. Гэрээний үндэслэл хэсэгт спорт заалны зориулалтаар 1 жилийн хугацаанд ашиглуулахаар тусгасан ба үнэ төлбөргүй ашиглуулах асуудлыг уг гэрээгээр зохицуулаагүй, уг спорт заалны 2 давхарт Хэрлэн сумын 2 дугаар багийн Ахмадын зөвлөл давхар ашиглаж байгаа нь аудитын дүгнэлтийн гол асуудал болно.

2126050046

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээгээр бодлого, чиг үүрэг, нээлттэй байдлын чиглэлийн хэрэгжилтийн гүйцэтгэлийг 2025 онд 99.1 хувиар үнэлүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

The image shows a red rectangular official stamp of the State Audit Agency of the Eastern Province. Inside the stamp, there is a handwritten signature in black ink. The stamp contains Mongolian text, including the name of the agency and the title of the auditor.

Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
35	БАРАА МАТЕРИАЛ	8,923,590.00	4,420,650.00
354	Хангамжийн материал	8,923,590.00	4,420,650.00
35410	Бичиг хэргийн материал	1,608,890.00	1,599,650.00
35420	Аж ахуйн материал	7,314,700.00	2,821,000.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,923,590.00	4,420,650.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,402,921,159.62	3,306,705,394.70
392	Биет хөрөнгө	3,255,496,159.62	3,159,580,394.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,631,181,648.60	1,827,551,222.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	-126,546,810.22	-169,378,031.29
39203	Авто-тээврийн хэрэгсэл	179,305,877.00	168,186,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-26,584,733.93	-50,581,416.66
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	104,763,351.00	90,983,451.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-36,559,229.16	-39,942,019.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,803,202.00	33,809,202.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,494,139.25	-9,584,337.93
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,113,185,331.38	2,048,291,640.38
39215	Хуримтлагдсан элэгдэл	-611,558,337.79	-739,755,315.91
393	Биет бус хөрөнгө	147,425,000.00	147,125,000.00
39301	Програм хангамж	3,000,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,100,000.00	-900,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	147,495,000.00	146,525,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-970,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,402,921,159.62	3,306,705,394.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,411,844,749.62	3,311,126,044.70
51	Засгийн газрын хувь оролцоо	3,411,844,749.62	3,311,126,044.70
512	Хуримтлагдсан үр дүн	3,177,086,338.50	3,076,367,633.58
51210	Өмнөх үеийн үр дүн	2,370,547,071.94	3,177,086,338.50
51220	Тайлант үеийн үр дүн	806,539,266.57	-100,718,704.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234,758,411.12	234,758,411.12
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,411,844,749.62	3,311,126,044.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,411,844,749.62	3,311,126,044.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	253,012,400.00	354,852,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	253,012,400.00	354,852,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,012,400.00	354,852,200.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	1,078,651,950.00	214,695,574.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,078,651,950.00	214,695,574.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,078,651,950.00	214,695,574.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,331,664,350.00	569,547,774.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	495,567,081.06	636,675,627.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	472,656,459.28	616,214,755.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,113,018.22	255,334,606.82
210101	Үндсэн цалин	101,354,686.32	127,169,117.59
210102	Нэмэгдэл	68,252,890.26	95,959,757.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,084,500.00	14,580,000.00
210104	Урамшуулал	9,770,209.64	8,555,600.65
210105	Гэрээт ажлын хөлс	4,650,732.00	9,070,130.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,986,500.00	32,511,847.72
210201	Тэтгэврийн даатгал	16,425,986.57	22,325,963.34
210202	Тэтгэмжийн даатгал	1,898,100.00	2,632,272.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	936,913.43	1,245,993.72
210204	Ажилгүйдлийн даатгал	929,200.00	1,225,136.01
210205	Эрүүл мэндийн даатгал	3,796,300.00	5,082,482.60
2104	Хангамж, бараа материалын зардал	9,194,270.00	18,217,513.00
210401	Бичиг хэрэг	3,571,410.00	2,289,984.00
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	7,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,876,580.00	1,167,789.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,546,280.00	1,742,140.00
210408	Бараа материал акталсны зардал	-	5,917,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,741,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	40,800.00
210604	Урсгал засвар	-	4,700,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,509,000.00	17,220,800.00
210702	Дотоод албан томилолт	4,509,000.00	17,220,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,840,000.00	9,147,351.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,400,000.00	2,289,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	62,904.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	-	6,183,347.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	245,013,671.06	279,041,037.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,500.00	221,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,499,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	244,986,171.06	277,320,487.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,910,621.78	20,460,871.46

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	22,356,847.00	300,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,356,847.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	553,774.78	20,160,871.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	553,774.78	20,160,871.46
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	495,567,081.06	636,675,627.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	836,097,268.94	-67,127,853.04
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	29,558,002.37	33,590,851.88
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	29,558,002.37	33,590,851.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-29,558,002.37	-33,590,851.88
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	806,539,266.57	-100,718,704.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	253,012,400.00	354,852,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	253,012,400.00	354,852,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,012,400.00	354,852,200.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	253,012,400.00	354,852,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	253,012,400.00	354,852,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	230,101,778.22	334,391,328.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,113,018.22	255,334,606.82
210101	Үндсэн цалин	101,354,686.32	127,169,117.59
210102	Нэмэгдэл	68,252,890.26	95,959,757.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,084,500.00	14,580,000.00
210104	Урамшуулал	9,770,209.64	8,555,600.65
210105	Гэрээт ажлын хөлс	4,650,732.00	9,070,130.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,986,500.00	32,511,847.72
210201	Тэтгэврийн даатгал	16,425,986.57	22,325,963.34
210202	Тэтгэмжийн даатгал	1,898,100.00	2,632,272.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	936,913.43	1,245,993.72
210204	Ажилгүйдлийн даатгал	929,200.00	1,225,136.01
210205	Эрүүл мэндийн даатгал	3,796,300.00	5,082,482.60
2104	Хангамж, бараа материалын зардал	8,849,960.00	11,967,723.00
210401	Бичиг хэрэг	3,800,000.00	2,223,294.00
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	7,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,102,080.00	1,167,789.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	747,880.00	1,476,640.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,471,500.00	6,326,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	771,000.00
210604	Урсгал засвар	2,271,500.00	5,555,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,509,000.00	17,220,800.00
210702	Дотоод албан томилолт	4,509,000.00	17,220,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,971,800.00	9,227,351.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,400,000.00	2,289,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	142,904.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	571,800.00	440,000.00
210807	Газрын төлбөр		6,183,347.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	1,802,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	311,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	1,490,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,910,621.78	20,460,871.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,356,847.00	300,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,356,847.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	553,774.78	20,160,871.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	553,774.78	20,160,871.46
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	253,012,400.00	354,852,200.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	234,758,411.12	2,370,547,071.94	2,605,305,483.06
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	234,758,411.12	2,370,547,071.94	2,605,305,483.06
Тайлант үеийн үр дүн	-	806,539,266.57	806,539,266.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	234,758,411.12	3,177,086,338.50	3,411,844,749.62
Тайлант үеийн үр дүн	-	-100,718,704.92	-100,718,704.92
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	234,758,411.12	3,076,367,633.58	3,311,126,044.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
12200	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	356,162,400.00	334,800,260.02
122005	Төсвөөс санхүүжих	356,162,400.00	334,800,260.02
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	356,162,400.00	334,800,260.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	361,852,200.00	334,691,328.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	360,703,100.00	334,391,328.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	275,693,100.00	255,334,606.82
210101	Үндсэн цалин	128,126,500.00	127,169,117.59
210102	Нэмэгдэл	102,625,900.00	95,959,757.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,477,700.00	14,580,000.00
210104	Урамшуулал	20,355,000.00	8,555,600.65
210105	Гэрээт ажлын хөлс	9,108,000.00	9,070,130.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,461,600.00	32,511,847.72
210201	Тэтгэврийн даатгал	23,433,900.00	22,325,963.34
210202	Тэтгэмжийн даатгал	2,757,000.00	2,632,272.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,378,400.00	1,245,993.72
210204	Ажилгүйдлийн даатгал	1,378,400.00	1,225,136.01
210205	Эрүүл мэндийн даатгал	5,513,900.00	5,082,482.60
2104	Хангамж, бараа материалын зардал	14,240,100.00	11,967,723.00
210401	Бичиг хэрэг	2,830,000.00	2,223,294.00
210402	Тээвэр, шатахуун	7,100,000.00	7,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,450,000.00	1,167,789.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,860,100.00	1,476,640.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,626,900.00	6,326,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,071,000.00	771,000.00
210604	Урсгал засвар	5,555,900.00	5,555,800.00
2107	Томилолт, зочны зардал	17,480,000.00	17,220,800.00
210702	Дотоод албан томилолт	17,480,000.00	17,220,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,389,400.00	9,227,351.00
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	3,451,000.00	2,289,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,812,000.00	1,802,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	312,000.00	311,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,490,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,149,100.00	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,149,100.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,149,100.00	300,000.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	361,852,200.00	334,691,328.54

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 64.9 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- ЖДҮТ-д шилжүүлж өгсөн үндсэн хөрөнгөнөөс 64.9 сая төгрөгийн хөрөнгийг дутуу шилжүүлсэн байсныг залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 550.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 550.5 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 550,554.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 541,311.7 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ:" 2.2.1-т "унааны зардал," 2.2.2-т байрны зардал," 2.2.3-т "хоолны зардал" гэж заасныг зөрчиж хоолны нэмэгдлийг олгохдоо томилолтын хоолны зардалтай давхардуулан 0.9 сая төгрөг илүү олгосон.

5.2 Албан шаардлага

1. Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тоот тушаалаар баталсан "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг хэтрүүлэн 3.4 сая төгрөгийг зарцуулсан.
2. Хэрлэн сумын 2 багт байрлалтай спорт заалны зориулалттай барилгыг иргэн С.Өнөрхүүтэй орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтын гэрээгээр ашиглуулахаар байгуулсан. Гэрээний үндэслэл хэсэгт спорт заалны зориулалтаар 1 жилийн хугацаанд ашиглуулахаар тусгасан ба үнэ төлбөргүй ашиглуулах асуудлыг гэрээгээр зохицуулаагүй, уг спорт заалны 2 давхарт Хэрлэн сумын 2 дугаар багийн Ахмадын зөвлөл үйл ажиллагаа явуулж давхар ашиглаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Төрийн өөрийн өмчид энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох дараахь эд хөрөнгө хамаарна", 1-т төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө", 11 дүгээр зүйлийн 1-т "төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах", АИХ-ын 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 50 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг худалдан борлуулах, ашиглуулах, түрээслүүлэх үлгэрчилсэн журмын 1.5-д "байгууллагын өөрийн эзэмшлийн ашиглаж байгаа эд хөрөнгүүдийг өөрийн үйл ажиллагааг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

алдагдуулахгүйгээр эрх бүхий байгууллагын болон холбогдох хууль журмын дагуу бусад байгууллага, этгээдэд төлбөртэй болон төлбөргүйгээр ашиглуулж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг дутуу бүртгэсэн	1	64,893.7					1	64,893.7				
Дүн	1	64,893.7					1	64,893.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг хэтрүүлэн зарцуулсан	1	3,409.4	1		1	3,409.4						
Хоолны хөнгөлөлтийг томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан олгосон	1	0.9	1	0.9								
Спорт заалны ашиглалтыг иргэнтэй гэрээ байгуулан хариуцуулсан	1	547,145.5			1	547,145.5						
Дүн	3	550,555.8	1	0.9	2	550,554.9						